



**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны 03 дугаар сарын 17 өдөр

Дугаар 31.13/26

Улаанбаатар хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Аялал жуулчлалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дахь хэсэг, Аялал жуулчлалын мэргэжлийн нэгдсэн холбооны дүрмийн 28 дугаар зүйлийн 28.1.12 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.3 дах заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Аялал жуулчлалын мэргэжлийн нэгдсэн холбоо” НЭЗХЭ болон Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам хооронд байгуулагдах “Төрийн зарим чиг үүргийг нийтийн эрх зүйн хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх тухай” гэрээ байгуулах эрхийг Ерөнхийлөгч Т.Баттулга, Гүйцэтгэх захирал М.Нарангэрэл нарт олгосугай.
2. Гэрээний төслийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэгт заасан гүйцэтгэгчийн үүргийн зөрчилтэй холбоотой алдангийн зохицуулалтыг гэрээний төслөөс хасахаар шийдвэрлэсүгэй.
3. Гэрээний хэрэгжилтийн талаарх мэдээллийг тухай бүр удирдах зөвлөлд хүргүүлж байхыг Гүйцэтгэх захирал М.Нарангэрэлд даалгасугай.

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

